МЭДЭЭ · 2025 оны 2-р сарын 27

ТӨРИЙН АЛБА ХААГЧДАД АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан таниулах, хэрэгжилтийг хангах, төрийн албан хаагч нарын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр нэгж прокурорын газрууд сургалт, уулзалтуудыг зохион байгуулж байна.

Тухайлбал, Архангай аймгийн прокурорын газраас 19 сумын засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, агентлагийн дарга нартай уулзалт зохион байгуулж авлигын гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, хүлээлгэх хариуцлагын талаар мэдээлэл өгч, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, анхаарах асуудлын талаар зөвлөмж хүргүүлжээ.

Нийслэлийн Налайх, Багахангай дүүргийн прокурорын газраас авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, мэдээлэл өгөх хүрээнд тус дүүргийн засаг даргын тамгын газрын 50 гаруй албан хаагчдад сургалт хийж, цаашид дүүргийн

төрийн болон төрийн өмчит байгууллагуудын удирдах албан тушаалтнуудыг оролцуулан үе шаттай тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөжээ.



Мөн Төв, Хэнтий аймгийн прокурорын газраас аймаг, сумдын засаг дарга болон бусад төрийн албан хаагчдад авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчил, авлигын хор уршиг, үр дагаварын талаар яриа таниулга хийж, цаашид гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах талаар санал солилцсон байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1093